

02



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 142

Номгон

Аялал жуулчлалыг дэмжих мэргэжлийн
зөвлөлийн бүрэлдэхүүнийг байгуулж, ажиллах
журмыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн II хуралдааны 2/6 дугаар тогтоол Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4 дүгээр бүлгийн 4.2.2 дах заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн аялал жуулчлалын салбарын бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэх, салбар хоорондын уялдааг хангах чиг үүрэг бүхий “Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг нэгдүгээр, “Баянхонгор аймгийн аялал жуулчлалыг дэмжих мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аялал жуулчлалыг дэмжих мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжиж гаргасан бодлого, шийдвэр, зөвлөмжийг аймгийн бодлогод тусгаж хамтран ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-т даалгасугай.



ДАРГА

Э.ЭНХБАТ

0121314

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 22-ны
өдрийн 142 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ДЭМЖИХ МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга Ю.Болдбаатар (Монгол улсын Шинжлэх ухаан технологийн
их сургуулийн багш, Түүхийн ухааны доктор /Ph.D/)

Нарийн бичгийн дарга Д.Содномсамдан (Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын аялал жуулчлалын ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Г.Энхбаяр (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч,
Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн асуудал хариуцсан хорооны дарга, аймгийн
Засаг даргын орлогч)

Д.Гансүх (Аялал жуулчлалын боловсрол сургалт, судалгааны төвийн
тэргүүн, доктор /Ph.D/)

Я.Цэрэндагва (Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэнгийн
археологич, доктор /Ph.D)

Н.Эрдэнэбат (Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын
зөвлөлийн тэргүүн)

Ц.Сэр-Од (Боловсролын Их Сургуулийн Газар зүйн тэнхимийн багш)

С.Шинэцэцэг (МАТО-ын удирдах зөвлөлийн гишүүн)

О.Баярсайхан (Гэрэл зурагчин, тур оператор компаний төлөөлөл)

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 22-ны
өдрийн 142 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ДЭМЖИХ МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Аймгийн аялал жуулчлалыг дэмжих мэргэжлийн зөвлөл /цаашид “Аймгийн Иргэдийн хурлын дэргэдэх аялал жуулчлалыг дэмжих мэргэжлийн зөвлөл” гэх/-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Зөвлөл нь аймагт аялал жуулчлал хөгжүүлэх бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэх, салбар хоорондын уялдааг хангах чиг үүрэг бүхий орон тооны бус бүтэцтэй байна.

1.3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Аялал жуулчлалын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

1.4. Зөвлөл нь Баянхонгор аймаг, хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймагт аялал жуулчлал хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, хөтөлбөрийг удирдлага болгоно.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Зөвлөлийн дарга нь аймгаас гарвалтай аялал жуулчлалын болон соёлын өв, түүхийн чиглэлээр мэргэшсэн, туршлагтай эрдэмтэн, судлаач, хувь хүн, иргэн, зөвлөлийн нарийн бичгийн дарга нь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга болон тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн байна.

2.2. Зөвлөлийн гишүүдээр аймгийн ИТХ-ын дэргэдэх тухайн салбарын бодлогын хорооны дарга, аялал жуулчлалын салбарын судлаач, багш, тур оператор байгууллагын төлөөлөл, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөлөл ажиллана.

2.3. Зөвлөлийн шийдвэрээр тухайлсан асуудлаар мэргэжлийн салбар зөвлөл, шинжээчдийн баг ажиллуулж болно

2.4. Зөвлөлийн гишүүдийн тоо сондгой байна.

ГУРАВ. ЗӨВЛӨЛИЙН ЧИГ, ҮҮРЭГ

3.1. Зөвлөл нь дараах асуудлыг хэлэлцэж, зөвлөмж гаргана

3.1.1. Аймгийн аялал жуулчлалын нөхцөл байдал, тухайн жилд аялал жуулчлалын бодлого, зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр нутгийн захиргааны байгууллагуудаас явуулсан ажлын тайлан, үйл ажиллагаа

3.1.2. Дараагийн төсвийн жилд аялал жуулчлалын чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, төсвийн тооцоо, санхүүжилтийн эх үүсвэрийн санал гаргах

3.1.3. Салбар дундын байгууллага хоорондын зохицуулалтыг хангах талаар шаардлагатай дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх асуудлууд

3.1.4. Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, гадаад, дотоодын иргэд, жуулчидтай холбоотой яаралтай хэлэлцэн шуурхай арга хэмжээ авах шаардлагатай асуудлууд

3.1.5. Тодорхой асуудлаар байгуулсан ажлын хэсэг, шинжээчдийн багийн үйл ажиллагааны тайлан, зөвлөмж

3.1.6. Зөвлөлийн даргын хэлэлцүүлэхийг зөвшөөрсөн бусад асуудлууд

ДӨРӨВ. ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭЛБЭР, ЖУРАМ

4.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

4.2. Зөвлөл хагас жилд нэгээс доошгүй удаа хуралдана. Хурлыг зөвлөлийн дарга зарлаж, даргалах бөгөөд түүний түр эзгүйд орлогч дарга зарлаж, даргална.

4.3. Зөвлөлийн дарга шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

4.4. Хурлын товыг хуралдаан болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд мэдэгдэж, хэлэлцэх асуудлын жагсаалт, холбогдох бичиг баримтыг хүргүүлсэн байна.

4.5. Нийт гишүүдийн 50-иас дээш хувь оролцсоноор хуралдаан хүчин төгөлдөр болно.

4.6. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд биеэр оролцох боломжгүй гишүүн хурал эхлэхээс өмнө саналаа бичгээр хүргүүлж болно.

4.7. Хурлын тэмдэглэлийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтөлнө.

4.8. Шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн хуралдаанд мэргэжлийн хүмүүсийг оролцуулж болно.

ТАВ. ЗӨВЛӨЛИЙН БУСАД ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, төрийн болон ТББ-аас холбогдох мэдээллийг гаргуулан авах;

5.2 Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд дүгнэлт өгөх ажлын хэсэг байгуулан ажиллуулах,

5.3 Байгууллагуудын ажлын уялдаа холбоо, иргэд, ТББ-ын оролцоог нэмэгдүүлэх, зарим ажлын гэрээ, тендерийн шалгаруулалт хийх.

5.4 Аялал жуулчлалын гадаад харилцааг өргөжүүлэх, харилцаат хотуудтай харилцан туршлага солилцох, үзэсгэлэн, ур чадварын уралдаан өдрийг зохион байгуулах, санал өгөх, зөвлөх

5.5 Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, ажилчдын мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалтанд хамруулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх

5.6 Үндэсний ардын уламжлалт соёл, зан заншилыг олон улс, гадаад оронд сурталчилан таниулах, хөгжүүлэх

5.7 Аймгийн аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал гаргах

5.8 Аймаг, сумын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын хууль бус үйл ажиллагаа явуулж буйг зогсоох, цуцлах саналыг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх

5.9 Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд идэвхи зүтгэл гаргаж, гавъяа байгуулсан иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийг алдаршуулах, шагнаж урамшуулах тухай саналаа холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх

5.10. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь:

- хуралдааны бэлтгэлийг хангаж, гарсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг нэгтгэн, зөвлөлийн дарга, орлогч дарга, гишүүдийг мэдээллээр хангана.

- Зөвлөлөөс мэргэжлийн салбар зөвлөл, шинжээчдийн баг ажиллуулсан тохиолдолд зөвлөлийн нарийн бичгийн дарга тэдгээрийг өдөр тутмын удирдлагаар хангаж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулна.

5.11. Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг тухайн оны 11 сарын эхний 7 хоногт багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тавина.